

МЭДЭЭЛЭЛ

2024.09.04




УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын Засаг дарга Б.Ганбаяр ажлаа ёгч Засаг Даргын Уурэг гүйцэтгэгчээр Э.Баттулга хүлээн авлаа.




УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




Сумын Засаг даргын зөвлөлийн 9 дүгээр хуралдаан болж байна.

Хэлэлцэх асуудал


- Наадмын хандив, тайлан
- Сумын Засаг даргын нөөц зарцуулалт
- Онцгой байдлын бэлэн байдлын Узлэг сургалтын талаар
- Монгол тургатан контентийн талаар
- ЗДТГ, цэцэрлэгийн дээврийн асуудал
- Орон нутгаас сурч байгаа оюутанд дэмжлэг узүүлэх тухай асуудлуудыг хэлэлцэж ажиллаа.





- “Эсгий түүргатан” нүүдэлчин соёлын өвийг дэлхийд түгээн таниулах баримтат цуврал нэвтрүүлгийн баг Баянтал сумын 2-р баг Шилийн худагт унага тамгалах зан үйл , дэмбээ наадгайны талаарх зураг авалт хийсэн.
- Сүм орон нутгийн зүгээс малчдаа хамруулах, өв соёлоо сурталчлах, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.



- Баруун гэр хороололд болон темөр замын 18-р зөвлөгийн гэр хороололд шинээр бетонон шон бүхий 6 гэрэлтүүлгийг Засаг даргын тамгын газраас хөрөнгийг нь гаргаж байршуулсан.
- Хуучин эвдэрсэн шон бүхий гэрэлтүүлгийг засварлаж 152 -105 -р байрнуудын хооронд харанхуй хэсэгт байрлуулна.






Баянталуу мөлдөөнүүдөйн таңбасарын жалғыз жана
Ордоңдын хөтөө бүйүнчүүлүгүнүүдөйн таңбасарын жалғыз жана
нирделүүдөйн таңбасарын жалғыз жана
Баянталуу мөлдөөнүүдөйн таңбасарын жалғыз жана



► Сумын ИТХ-н дарга, Засаг дарга,
Багийн Засаг дарга нар хадлан, ёвс
тэжээл бэлтгэж буй газруудад
ажиллаж байна.






**“Говийн улиас” ХХК 10га газар хашаажилтанд
дахин засвар үйлчилгээ хийж 233 шон хийсэн.**




“Лүн” багийн Засаг дарга малчдаараа
тойрон явж БИНХ-н зaryг 15 өрхөд
хүргэсэн.



Хэлэлцэх асуудал: Сумын газрын
төлөвлөгөөнд санал авах



► Сумын удирдлагууд аймгийн цахилгаан эрчим хүчиний удирдлагуудтай уулзаж зуун гэр хорооллын цахилгааны КТПН-04 шугамыг 09-р сарын 05-ны өглөө холбооор боллоо.



► Нохой устгал явагдаж байна.








► 2-р баг буюу 18-р зөрлөгийн гэр хорооллын дунд, сумын төвийн баруун гэр хорооллын хойд хэсэгт бетонон шон бүхий 2 цамхаган шинэ гэррүүдийг асаасан.


► Цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлийг хэвийн ажиллагаанд оруулахаар ажиллаж байна.

► Цэцэрлэг, тамгын газрын дээврийн цуурсан бороо гоождог хэсгийг цавуу, хар цаасаар нааж янзалсан.



ОРОН НҮҮТГИЙН ХӨГГИЛҮҮН СААНГИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Спорт залын барилга түүчиндээ гарах тэндээ
2024 оны 07-р сарын 18-ны өдөр амжилттай
засварлагж "Худалдаан" ХХК улсын
08-р сарын 26-ны өдөр гэрээг байгуулсан.






Санхүү төсөв: 4 дүгээр сарын орлогын бурдүүлэлтийн талаар

2024 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар 129,580.0 мянган төгрөг төлөвлөгөө батлагдсанас гүйцэтгэлээр 253,756.1 мянган төгрөг буюу 196.0 хувиар орлогыг давуулсан биелүүлсэн байна.

Баянтал сумын нэгтгэлийн /ОН/ өглөг 2,893.6 мянган төгрөг , авлагага 4,341.9 мянган төгрөг байна. Үүнд: урьд оны НДШ-ийн өглөг 2,893.7 мянган төгрөгийн өглөгтэй байна.

2024 оны 8-р сарын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл





Санхүү төсөв: Статистикийн Мэдээллийн талаар

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дугээр сарын 11-ны өдрийн А/35 дугаар захирамжаар ХАА1, ХАА2, ХААЗ, Маягтуудын Мэдээллийг оны эхнээд Сумын багийн Засаг дарга нар гаргаж, сумын санхүү албаны мэргэжилтэнгүүд төдөө.app.mso.mpp программ шивж байна. Сумын хэмжээнд 1 аж ахуй нэгж, 12 иргэн хүнсний ногоо тариалсан байна. Нийт тариалсан талбай. Га 5.86224, үүнээс төмс 2.1 га, Хүнсний ногоо 3.74994 га талбайд тариалалт хийсэн байна. 2024 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар хураасан 5 төрлийн хүнсний ногоо нийт 1.7835 тн хураасан байна.



Байгаль орчны чиглэлээр хийсэн ажил

Монгол улсын Амьтны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2.1 дэх заалт Идлэг шонхор шувууг соёлын зориулалтаар баруулах тоо хэмжээг тогтоох тухай Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-н өдрийн 224 дүгээр тогтоол, Ерөнхийлөгчийн Тамгын газрын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн ТГ/399 дугаартай албан бичиг, Байгаль орчин ялалт жуулчлалын сайдын 2024 оны А/548 дугаар тушаал, Говьсүмбэр аймгийн Засаг даргатай байгуулсан 01 дүгээр гэрээ болон тусгай зөвшөөрлийг тус тус үндэслэн нэг талаас Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Засаг даргын тамгын газар, нөгөө талаас Арабын Нэгдсэн Эмират Улсын Ерөнхийлөгч Эрхэмсэг дээд ноён Н.Н Sheik Mohamed Bin Zayed Al Nahyan(цаашид “Бэлэг хүлээн авагч” гэх) түүнийг төлөөлөн, итгэмжлэгдсэн төлөөлөгч ibrahim Husien (паспортын дугаар 013658191) нар 2 ширхэг шонхор шувуу барилцан тохиролцож гэрээг Үндэслэн Сүмийн засаг дарга гэрээг байгуулан ажиллаж сумын Орон нутгийн өрөнхий орлого нийт 44,370.0 мянган төгрөгийг 2024 оны 08 дугаар сарын 29-ны өдөр ан агууруын дансанд 41,760.0 мянган төгрөг, улсын тэмдэгийн хураамж дансанд 2610.0 мянган төгрөгийг тус тус оруулан ажилласан байна. Мөн 1 идлэг хонхорын гэрээ 9 сарын 01-ны өдөр хийж ажиллаа.

Хичээлийн шинэ жилийн уттан 2024 оны 08 дугаар сарын 30-нд суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон аж ахуй нэгж иргэдийн оролцоотойгоор нийтийн эзэмшилийн зам талбай хүрээн буй орчин, нийтийн их цэвэрлээг зохион байгуулан ажиллаж нийт төсвийн 5 байгууллага, 2 аж ахуй нэгж хамрагдан өөрийн байгууллагын харьягдсан 50 метр газраа цэвэрлээн ажиллаа.



Байгаль орчны чиглэлээр хийсэн ажил

- Говьсумбэр аймгийн Баянтал суманд байрлах Худээрийн үйлдвэр “Бигом Чойр” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд Хуучин Орос Цэргийн анги болон Стадионы туурь хог хаягдалыг зөвверлөж, цэвэрлэх ажлыг сумын ЗДТГ-тай хамтран гүйцэтгэлээ.
- 1. Баянтал сумын урд талд засмал замаас сумруу орж ирэх замын хажууд хоёр овоолго туурь хогийг ачиж Цэвэрлэсэн Мэн Цагаан хаалгын урдах хуучин стадионы ойр орчимын нийтийн эзэмшилийн талбайд байгаа цементэн болон блок туурь хог хаягдалыг бөөгнүүлэн цэвэрлэж хаясан.
- 2. Энэ туурь хогийг цэвэрлэхэд “Бигом Чойр” ХХК-аас автомашин болох NOVO сонсмол, KOVSH зэрэг техник хэрэгсэлүүдийг ашиглаж хурсан хог хаягдалыг ачиж тээвэрлэж булашлуулан ажилласан байна. Түнд шаардагдах шатахууны зардал болох NOVO сонсмол автомашинд 150л дизель тулши, KOVSH техник хэрэгсэлд 200л бугд 350 литр дизель тулшийг *3600-аар нийт 1,260,000 төгрөгийн шатахууны зардлыг ЗДТГ-ын Хур хог хаягдлын зардлаас шийдвэрлэн гаргаж “НЭБУ” ХХК-аас шилжүүлэн ажиллаа.





Байгаль орчны чиглэлээд хийсэн ажил

анх түүрүү хог, овоолго

Хоёр дахь түүрүү хог хаягдал



Стадионы баруун урд талын битмөнөн хог





Байгаль орчны чиглэлээр хийсэн ажил


Түүр хог хаягдлыг цэвэрлэж буй явц





Байгаль орчны чиглэлээд хийсэн ажил

Дууссаны дараа



Цэцэрлэг

► Хичээлийн шинэ жил эхлэж байгаатай холбогдуулан байгууллагын дотор болон гадна засварын ажил хийгдсэн.

► 2024.08.23-ны өдрөөс эхлэн СӨБ-д хамрагдах 2-5 настай хүүхдийн буртгэл хийгдсэн бөгөөд нийт 75 хүүхэд буртуулсэн.

► “Сүмбэр 3 бат” ариутгалын газартай хамтран байгууллагын дотор болон гадна ариутгал, шавьжгүйтгэлийг хийсэн.

► 9-р сарын 01-нд Нээлтийн үйл ажиллагаа хийсэн.







Нийгмийн бодлогын хүрээнд - Сургалт

Ерөнхий боловсролын сургууль

- 2024 оны 08 дугаар сарын 29-нд сум хөгжүүлэх сангийн 24.4 сая төгрөгийн шинэ суурин компьютер, ширээ сандалыг мэдээлэл зүйн кабинетд хулээн авлаа.
- 2024 оны 08 дугаар сарын 22-31 хооронд сургуулийн нийтийн эзэмшиглийн талбай, дотуур байр, спорт заал, кабинетуудад их засвар, цэвэрлэгээ УЙЧИЛГЭЭ хийсэн.
- 2024 оны 08 дугаар сарын 28-нд сургуулийн нөхөн хангалтын зардлаар шийдвэрлэгдсэн 70,75 инчийн 9 зурагтыг АУБ наарт гардуулж анги удирдсан багш нар ангидаа байршуулсан.
- 2024 оны 08 дугаар сарын 30-нд хичээлийн шинэ жилийн нээлтийн “Багш нарын бага хурал” ГСА-т зохион байгуулдаж 9 багш 4 удирдлага оролцсон.
- 2024 оны 09 дүгээр сарын 01 -ны өдөр сургуультай танилцах өдөрлөгийг сурагч эцэг эхэд зохион байгуулж ирэх хичээлийн жилд хийх ажлын саналыг эцэг эхчүүдээс авч ажиллаа. Өдөрлөгт давхардсан тогoor 100 эцэг эх хамрагдсан.
- 2024 оны 09 дүгээр сарын 01 -ны өдөр Үндсэн хууль сэдэвт МУ ерөнхийлөгчийн цахим хичээлийг зохион байгууллаа. Уг хичээлтэй бага дунд ангийн 133 сурагч хамрагдсан.
- 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр сургуулийн ажилчид хуваарийн дагуу сургуулийн хичээлийн байр болон спорт заалт орчмын 50м зам талбайг цэвэрлэж ажилласан.




Нийгмийн бодлогын хүрээнд

Соёлын төв

Э-р сарын 01-03-ны өдрүүдэд Боржигин чуулгын талбайд зохион байгуулагдсан “Эх хэлний өдөр” болон “Соёл урлагийн ажилтны баяр”-ыг ургасан “Бүх нийтийн соёлын боловсрол олгох өдөрлөг”-т Баянтал сумын Соёлын төв нь:

- Үндэсний бичгээр хэвлэгдсэн ховор хуучин номны Узэсгэлэн хөтөлбөр наадгай, харваац тоглоом
- Чойрын хүн үламжлалт наадгай “Халз хээ
- Үндэсний тоглоом уламжлалт наадгай
- Боржигин Монголын уламжлалт хээ
- Баянтал сумын Соёлын бүтээлч Үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээлийн Узэсгэлэн худалдаа зөргээр оролцож байна.




Соёл, спорт, аялал жуулчилал, запуучуудын яамны дэмжлэгээр Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Соёлын төв, ордны дүү гэрлийн техникийн чадавхыг бэхжүүлэх, мэргэшүүлэх”, сургалтанд техникийн ажилтан О.Бадамцэцэг хамрагдаж мэдлэг ур чадвараа дээшлүүллээ.



8-р сарын 27-ны өдөр Боржигин түмний өв соёлыг сурталчилан таниулах, хойч үедээ өвлөн уламжлуулах зорилготой “Эсгий түүргатан” нэвтрүүлэгт байгууллага хамт олон сумын соёлын өвийг өвлөн уламжлагчдын хамт оролцлоо.




Нийтийн Цэнгүүнийг 8-р сарын 23-ны өдөр зохион
байгуулж 31 хүн хамрагдсан байна.



НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД – ЭРҮҮЛ МЭНД

Амбулаторын үзлэг - 208
Яаралтай тусlamж- 54
Идэвхитэй хяналт-2
Өдрийн эмчилгээ- 3
Хэвтэн эмчилгээн- 20
Гэрийн эргэлт - 1
Нярайн эргэлт- 2
Товтолт дархлаажуулалт -8
Алсын дуудлага Том хүн- 1 хүүхэд-0
Ойрын дуудлага-Том хүн-18 хүүхэд- 5
Зам тээврийн осол- 0
Сахарын шинжилгээ - 13
Тэмбүү-21
Док-20
Ц Верус-21
Б. Верус-21

Монгол Улсад Улаанбурхан өвчин зөөверлөгдөн ирж батлагдсантай холбогдуулан Улаанбурхан, улаануудын эсрэг вакцинд эрүүл мэндийн ажилтнууд болон сургууль, цэцэрлэгийн багш, ажилчдад бүрэн дархлаажуулалтад хамрагдсан.



Нийтийн үйл ажиллагаа- Эрүүл мэнд

"Цусны даралт ихсэлтийн эсрэг аян 2024"-ийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, улсын гуравдугаар эмнэлэг, Хаан банктай хамтран зохион байгуулсан арга хэмжээнд Эрүүл мэндийн төвийн 2 эмч оролцож иргэдэд эмчилгээ үйлчилгээ үзүүлсэн.



Дотоод үйл ажиллагаа

* Эрүүл мэндийн төв нь байгууллагынхаа хашаан доторх болон хашааны гадна талын шарилжийг хадсан.



БАЯНТАЛ СҮМ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ

БАЯНТАЛ СҮМ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛДА